

НИСЭХ БУУДЛУУДЫН УДИРДАХ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

2020.06.22

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын баталсан 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн “ИНЕГ-ын Нисэх буудлуудын удирдах газрын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай” 13/20 тоот удирдамжийн хүрээнд 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдрийг дуустал хугацаанд ИНЕГ-ын НБУГ-ын /хуучин бүтцээрх/ үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор П.Цогбаяр, А.Мөнх-Эрдэнэ, Т.Саранчимэг, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Ц.Цацрал, Б.Болормаа, Ц.Оюут нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд НБУГ-ын 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны касс, харилцах дансны үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, анхан шатны баримт бүрдүүлэлт, захиргаа, дотоод хяналтын үйл ажиллагаа, мөрдөгдөж буй дүрэм, журмын хэрэгжилт, шилэн дансны хуулийн хэрэгжилт, бараа материалын бүртгэл зэргийг нягталж шалгахаас гадна зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа. Зарим үйл ажиллагааны хамрах хүрээг аудитын нөхцөл байдлаас шалтгаалан 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс тооцсон болно.

НБУГ-ын даргын тушаалын төсөл боловсруулахдаа утга, найруулга болон үг үсгийн алдаатай бичдэг. Тушаалын үндэслэл хэсэгт хүчингүй болсон хуулийн зүйл, заалтыг зохицуулалт болгож өгснөөр эрх зүйн чадамжгүй тушаалууд гаргасан байна. ИНЕГ-ын Хөдөлмөрийн дотоод журмын холбогдолгүй заалтыг тушаалын хууль эрх зүйн үндэслэлд оруулж алдаатай тушаал гаргасан.

НБУГ-ын даргын тушаалын төслийг боловсруулсан болон хянасан ажилтнууд “Баримт бичгийн бүрдлүүд, тэдгээрт тавих шаардлага”, “Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрлүүдийг байрлуулахад тавих шаардлага”-т заасан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, “Баримт бичиг боловсруулсан тухай тэмдэглэлийн бүрдэл”-ийн талаар MNS 5140:2011 стандартад заасан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Гадны байгууллага, иргэдэд явуулсан албан бичгийн бүртгэлийн товъёгийг буруу дугаарласан, үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус албан бичгийн ангиллыг буруу хийсэн зэрэг зөрчил илэрсэн.

Ажилтнуудын цалинтай болон цалингүй чөлөө авсан хүсэлтийг бүртгэлд тусгадаггүй, архивын нэгж болгож үдэж цэгцлээгүйгээс өргөдөл алга болсон, эсхүл өргөдөл хүсэлтгүйгээр чөлөө олгож хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн байна.

НБУГ-ын ажилтнуудын 2019 оны ажлын гүйцэтгэл, үр дүнг нэгдсэн стандартын дагуу үнэлж дүгнээгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хүчингүй болсон анхан шатны бүртгэлийн маягыг ашиглаж байсан.

Цалин хөлс, хоолны үнийн хөнгөлөлтийн тооцоогоор зөрчил илэрсэн.

Нягтлан бодох бүртгэлд бараа материалын ангиллыг буруу бүртгэсэн. “Санхүүгийн цогц иж бүрэн програм”-ын ашиглалт хангалтгүй байна.

Шилэн дансны цахим хуудаст мэдээллийг хугацаа хоцроож оруулдаг, буруу, дутуу мэдээлсэн, худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой мэдээллийг мэдээлээгүй.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.4, 8.5 дахь заалтууд, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан босго үнийг зөрчиж шууд худалдан авалт хийсэн байна.

Шинээр байгуулагдсан ИНҮТ-ийн зохион байгуулалтын бүтцээр НБҮГ-ын харьяанд Дотоод хяналтын тасаг ажиллаж байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-д заасан дотоод хяналт шалгалтын нэгж нь байгууллагын удирдлагад шууд захирагдах бөгөөд зохион байгуулалтын хувьд бусад бүтэц, нэгжээс хараат бус байх гэсэн дотоод хяналт шалгалтын зарчимтай нийцэхгүй байна.

Дотоод хяналтын тасгийн эрсдэл, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтний 2019 онд хийсэн эрсдэлийн үнэлгээ нь зөвхөн үл тохирол үүссэний дараа үр дагаврыг үнэлсэн буюу мэдэгдэж байгаа эрсдэлийн хүрээнд ажилласан байгаа нь ажил байдлын тодорхойлолтоор хүлээсэн байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох чиг үүргийг хангалтгүй биелүүлсэн. Дотоод хяналтын тасгийн орон нутгийн нисэх буудлуудыг хариуцсан хяналтын ахлах мэргэжилтэн нь албан тушаалын тодорхойлолтод заагдсан зарим зорилтуудыг хангалттай хэрэгжүүлж ажиллаагүй.

Нисэх буудлуудын удирдах газрын /хуучин бүтцээр/ үйл ажиллагаанд хийгдсэн аудитын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлууд нь Иргэний нисэхийн үндэсний төв дээр давтагдан гарах эрсдэл өндөр тул аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар Иргэний нисэхийн үндэсний төвд 14 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА